

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМ
АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛЬ

Гар бичмэлийн эрхтэй ©

БАТ-ОЧИРЫН УДВАЛЦЭЦЭГ

**СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ХЭРЭГЛЭЭ, ХОР УРШГИЙН ТАЛААРХ
ӨСВӨР ҮЕ, ЗАЛУУЧУУДЫН ОЙЛГОЛТ, ХАНДЛАГА**

E09180101 Нийгмийн эрүүл мэнд

Нийгмийн эрүүл мэндийн магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл

Улаанбаатар хот

2017 он

УДИРТГАЛ

Үндэслэл: Согтууруулах ундааны хэрэглээтэй холбоотой хор уршиг нь дэлхий нийтийн, бүс нутгийн хүн амын хувьд анхаарал татсан асуудлын нэг болж байна.¹

Монгол улсын үндэсний хэмжээнд хийгдсэн ХБӨ-ний эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын түвшин тогтоох шаталсан судалгаагаар (2005, 2009, 2013) нийт хүн амын дунд хэрэглээний түвшин төдийлөн буураагүй бөгөөд сүүлийн судалгаанд 15-24 насны хүн амын 15,9 хувь нь сүүлийн 30 хоногт ямар нэг хэмжээгээр согтууруулах ундааг хэрэглэсэн ба дунджаар 3.2 удаа, нэг удаад 5.9 стандарт уулт уусан байна. Энэ насны эрчүүдийн 12.2 хувь нь хэтрүүлэн хэрэглэдэг байна.²

Улаанбаатар хотын ЕБС-ийн сурагчдын дунд согтууруулах ундааны хэрэглээг судлахад 21.1 хувь нь ямар нэг хэмжээгээр хэрэглэдэг ба хэрэглэж эхэлсэн дундаж нас 14.3 ± 3.6 байна. Эрэгтэй сурагчид эмэгтэйдээс 1.3-2.4 дахин их байна ($p < 0.001$).³

Архинд донтох, архины хамааралт өвчний үед бие хүний доройтлын (хөдөлмөрийн чадвар болон оюун ухааны бууралт) шинжүүд гүнзгийрч, тухайлбал судалгаанд хамрагдсан 20-29 насны хүн амын дунд механик ой, харааны ой, богино хугацааны ой буурсан байна.⁴

Архинд донтсон өвчтөний бие хүний сэтгэцийн чанарын онцлогуудыг судалсан судалгааны дүнгээр архинд донтох эмгэгтэй хүмүүст 2 төрлийн сэтгэцийн илрэлийн хөдлөл зүй илэрч байна. Сэтгэл хөдлөл тогтворгүй, оюун ухааны хүчин зүйлс сул хөгжсөн онцлогтой хүмүүст бие хүний өөрчлөлт (эмгэг сэдэл ихсэх, аминч болох г.м) тод илэрч, бие хүний доройтол (ажилгүйдэл, хууль журам зөрчих, танин мэдэхүйн бууралт) байдлаар өвчин даамжирдаг байна.⁵

Монгол улсад архинд донтох өвчний тархвар зүйн судалгаагаар сүүлийн 15 жилд 10000 хүн амд 230 байгаагаас хотод хөдөө орон нутгаас 3.1 дахин их бөгөөд аажим өсөх хандлага ажиглагдаж, сэтгэцийн бүх өвчний дотор 5.4 дахин ихэссэн үзүүлэлттэй байна.⁶

ХБӨ-ний талаарх хүн амын мэдлэг, хандлага, дадал судалгаагаар архи согтууруулах ундааны зохистой хэрэглээний талаарх хүмүүсийн мэдлэг хангалтгүй байна, залуучууд архи согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэх хандлагатай байна.⁷

Архины хурц хордлогын улмаас хордлогын төвд хэвтэн эмчлүүлсэн нийт 440 үйлчлүүлэгчийн 83.4 хувь нь эрэгтэй, 25 хувь (110) нь 20 хүртэлх насны, 22.05 хувь нь 21-30 насны, нийт эмэгтэй үйлчлүүлэгчийн 71.2 хувь (52) нь 20 хүртэлх насны охид байна.⁸

Монгол хүний согтууруулах ундааны хэрэглээний байдал, түүний онцлогийг судалсан судалгааны дүнгээр судалгааны нийт хүн амын 38.1% нь согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэдэг, ялангуяа Улаанбаатар хот (49.2%) болон хангай (45.3%), төвийн (46.2%) бүсүүдэд бусад бүсээс статистик ач холбогдол бүхий өндөр байна ($p < 0.05$). Насны хувьд авч үзвэл 15-24 насныхан 31.6 хувь байгаа нь өндөр үзүүлэлт юм. Гэвч ийлдсэн дэх алкогольдегидрогеназа ферментийн дундаж хэмжээ 18.5 ± 12.8 нг/мл байгаа нь европчуудаас 3.5 дахин бага байна. Ийнхүү Монголчуудын дунд архины хэрэглээ, түүний дотор хэтрүүлэн хэрэглээ өндөр байтал харин задлагч ферментийн идэвх бусад улс, үндэстнээс бага байгаа нь согтууруулах ундаанд байгаа этилийн спиртийг задалж, хоргүйжүүлэх чадвар Монгол үндэстэнд сул байгааг харуулж байна.⁹

Улсын хэмжээнд 2015 онд согтуугаар үйлдсэн гэмт хэргийн 49.7 хувь, мансуурсан үедээ үйлдсэн хэргийн 88.8 хувь нь Улаанбаатар хотод байна. Нийслэлд гарсан нийт хэргийн 28.6 хувийг 15-24 насны хүүхэд, залуус үйлдсэн байна.¹⁰

Ийнхүү согтууруулах ундааны хэрэглээтэй холбоотой эрүүл мэнд, нийгмийн сөрөг үр дагавар ихсэж байгаа нь энэхүү судалгааг явуулах үндэслэл болсон бөгөөд цаашид нотолгоонд тулгуурласан арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

Судалгааны зорилго: Согтууруулах ундааны хэрэглээ, хор уршгийн талаарх өсвөр үе, залуучуудын ойлголт, хандалагыг тодорхойлох

Судалгааны зорилт:

1. Өсвөр үе, залуучуудын согтууруулах ундааны хэрэглээ болон хэрэглээнээс үүссэн хор уршгийг судлах.
2. Согтууруулах ундааны хэрэглээг бууруулахаар хэрэгжүүлж буй арга хэмжээ, хууль эрх зүйн талаарх өсвөр үе, залуучуудын ойлголт, хандлагыг тодорхойлох.

Судалгааны ажлын шинэлэг тал

Согтууруулах ундааны хэрэглээ, хор уршгийг бууруулахад чиглэсэн арга хэмжээ, архидан согтуурахын эсрэг хэрэгжүүлж буй хууль эрх зүйн ойлголтыг үнэлсэн байдал нь хуулийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэхэд дэмжлэг болж ашиглагдах боломжтой.

Судалгааны ажлын практик ач холбогдол

Бидний судалгаанаас гарах согтууруулах ундааны хэрэглээний өнөөгийн байдал залуучуудын ойлголт, хандлага нь согтууруулах ундааны хор хөнөөлийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөх хэрэгжүүлэх, бодлого боловсруулахад мэдээлэл болох ач холбогдолтой.

Нэг сэдэвт бүтээлийн бүтэц, хэмжээ

Согтууруулах ундааны хэрэглээ, хор уршгийн талаарх өсвөр үе, залуучуудын ойлголт, хандлагыг судалсан НЭМ-ийн магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл нь удиртгал, хэвлэлийн тойм, судалгааны хэрэглэгдэхүүн, арга зүй, судалгааны үр дүн, хэлцэмж, дүгнэлт гэсэн 4 бүлэг, ном зүй, хавсралт бүхий 64 хуудастай болно.

Судалгааны үр дүнг хэлэлцүүлсэн байдал

1. НЭМС-ийн Зан үйл, нийтийн эрүүл мэндийн тэнхимийн 2016 оны 11 сарын 24 өдрийн №16/26 хурлаар судалгааны ажлын сэдэв, арга аргачлалыг хэлэлцүүлсэн.
2. Судалгааны арга аргачлалыг АШУҮИС-ийн Судалгааны ёс зүйн хяналтын хорооны 2016 оны 12 сарын 02-ны өдрийн №3/20 хурлаар хэлэлцүүлж, судалгааны ажлыг эхлүүлэх ёс зүйн зөвшөөрөл авсан.
3. НЭМС-ийн Зан үйл, нийтийн эрүүл мэндийн тэнхимийн 2017 оны 5 сарын 03 өдрийн № 17/15 хурлаар судалгааны ажлын үр дүнгийн явцыг хэлэлцүүлсэн.

4. Судалгааны ажлын үр дүнг АШУҮИС-ийн Судалгааны ёс зүйн хяналтын хорооны 2017 оны 5 сарын 05-ны өдрийн №2017-06 хурлаар хэлэлцүүлж, судалгааны ажлын ёс зүйн дүрэм, журмуудыг зөрчөөгүй гэсэн дүгнэлт гарсан.
5. НЭМС-ийн Зан үйл, нийтийн эрүүл мэндийн тэнхимийн өргөтгөсөн 2017 оны 5 сарын 22 өдрийн № 17/18 хурлаар судалгааны ажлын үр дүнгийн урьдчилсан хамгаалалтыг хэлэлцүүлсэн.
6. НЭМС-ийн Эрдмийн зөвлөлийн 2017 оны 6-р сарын 09-ны өдрийн хурлаар судалгааны ажлын үр дүнг жинхэнэ хамгаалалтанд хэлэлцүүлсэн.

Судалгааны ажлын ёс зүй

Судалгааны арга аргачлалыг АШУҮИС-ийн Судалгааны ёс зүйн хяналтын хорооны 2016 оны 12 сарын 02-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, судалгааны ажлыг эхлүүлэх ёс зүйн зөвшөөрөл авсан болно. Ёс зүйн журмын дагуу уг судалгаанд оролцсон 15-18 насны хүүхэд бүрийн эцэг эх, хууль ёсны төлөөлөгчөөс зөвшөөрөл авч судалгааг явуулсан. Судалгаанд оролцогчдод судалгааны зорилго, судалгаа явуулах зарчим, мэдээллийн нууцлал, судалгаанаас гарах үр дүнгийн талаарх мэдээ, мэдээллийг зөвхөн эрдэм шинжилгээний зорилгоор ашиглах зэргийг тайлбарлан танилцуулж, судалгаанд оролцогчдоос таниулсан зөвшөөрлийн хуудсаар зөвшөөрөл авч явуулсан болно. Мөн АШУҮИС-ийн Судалгааны ёс зүйн хяналтын хорооны 2017 оны 5 сарын 05-ны өдрийн хурлаар судалгааны явцад олон улсын болон манай улсад мөрдөгдөж байгаа судалгааны ажлын ёс зүйн дүрэм, журмуудыг зөрчөөгүй гэсэн дүгнэлт гарсан.

Судалгааны ажлын үр дүнгээр хэвлэн нийтлүүлсэн бүтээл

Илтгэл:

1. Анагаах ухааны боловсрол, Сувилахуйн Эрдмийн чуулган–59 “Өсвөр үе, залуучуудын согтууруулах ундааны хэрэглээний эсрэг хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх мэдлэгийг үнэлсэн нь” №1(12) 2017:43-44
2. Нийгмийн эрүүл мэндийн салбар хуралдаан Эрдмийн чуулган–59 “Өсвөр үе, залуучуудын согтууруулах ундааны хэрэглээ, хор уршгийн талаарх ойлголт”.

Өгүүлэл:

1. Нийслэлийн ЕБС, МСҮТ болон их дээд сургуулиудын оюутан, сурагчдын согтууруулах ундааны хэрэглээг судлах нь. *Нийгмийн эрүүл мэндийн эрин сэтгүүл*. №10 2017:140-144.

ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	5
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	6
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	7
УДИРТГАЛ	8
Судалгааны ажлын үндэслэл	8
Судалгааны ажлын зорилго, зорилт	9
Судалгааны ажлын шинэлэг тал	9
Судалгааны ажлын практик ач холбогдол	9
Судалгааны ажлын үр дүнг хэлэлцүүлсэн байдал	10
Судалгааны ажлын ёс зүй	11
Судалгааны ажлыг хэвлүүлсэн байдал	11
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ХЭВЛЭЛИЙН ТОЙМ	12
1.1. Согтууруулах ундааны талаарх ерөнхий ойлголт	12
1.2. Согтууруулах ундаа хүний эрүүл мэндэд үзүүлэх хор хөнөөл	16
1.3. Согтууруулах ундааны нийгэмд үзүүлэх хор хөнөөл	20
1.4. Согтууруулах ундааны хэрэглээ	22
1.5. Согтууруулах ундааны талаарх эрхзүйн акт	26
ХОЁРДУГААР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН, АРГА ЗҮЙ	30
2.1. Судалгааны загвар	30
2.2. Судалгааны хүрээ ба түүвэр	30
2.3. Судалгааны мэдээ, материал цуглуулсан аргууд	31
2.4. Үр дүнгийн статистик боловсруулалт	34
2.5. Судалгааны хязгаарлагдмал тал	34

ГУРАВДУГААР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ ҮР ДҮН	35
3.1. Ерөнхий мэдээлэл	35
3.2. Согтууруулах ундааны хэрэглээ	36
3.3. Согтууруулах ундааны хэрэглээнээс үүдсэн сэтгэл зүйн нөхцөл байдал, хор нөлөө	43
3.4. Согтууруулах ундааны хэрэглээ, хор уршгийг бууруулахад чиглэсэн арга хэмжээний талаар мэдээллийн хэрэгцээ	47
3.5. Сургуулийн орчинд согтууруулах ундааны хор уршигтай хэрэглээг бууруулахаар хэрэгжүүлж буй арга хэмжээ	53
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХЭЛЦЭМЖ	54
СУДАЛГААНЫ АЖЛЫН ДҮГНЭЛТ	64
ЗӨВЛӨМЖ	
НОМ ЗҮЙ	
ХАВСРАЛТ	

НОМЗҮЙ

1. WHO. Global status report on alcohol and health 2014. World Health Organization; 2014.
2. ЭМЯ, ДЭМБ, НЭМХ, ММСС. Халдварт бус өвчин, осол гэмтлийн шалтгаан, эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын судалгаа. 2005 2009 2013.
3. Khishigtogtokh D. Prevalence of some risk factors for Non-Communicable Diseases among school children. 2012.
4. Гантөмөр Д. Архинд донтох өвчний үеийн ой, анхаарлын зарим өөрчлөлтүүд [АУ-ны магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл]. УБ 2008.
5. Гантөмөр Д. Архинд донтсон өвчтөний бие хүний сэтгэцийн чанарын онцлогууд [АУ-ны докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл]. УБ 2012.
6. Эрэдэнэбаяр Л. Эпидемиология, клиника и научно-организационные основы профилактики Алкоголизма в Монголии [Дисс. Канд. Мед.наук]. Томск 1997.
7. ММСС, НЭМХ. Халдварт бус өвчний талаарх хүн амын мэдлэг, хандлага, дадал. 2011.
8. Должин Х. Архины цочмог хордлогын эмнэл зүй оношлолт, цус шүүх эмчилгээний үр дүн [АУ-ны докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл]. УБ 2000.
9. Нарантуяа Н. Монгол дахь согтууруулах ундааны хэрэглээний байдал, түүний онцлог [АУ-ны докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл]. УБ 2013.
10. ЦЕГ. Гэмт хэрэг үйлдэгсдийн байдлын мэдээ. УБ 2015.
11. Эрдэнэбаяр Л. Донтолтын анагаах ухаан. УБ Сэлэнгэ пресс 2016.
12. Амарбат Б. Элэгний эсийн архины тухай эзэндээ хандсан тунхаглал. Инноваци - Шинэ Санаа, Шинэ Нээлт, 2(5-2). 2008.
13. Бямбасүрэн С. Мансуурал судлал. УБ 1999.
14. Harada S, Misawa S, Agarwal DP, Goedde HW. Liver alcohol dehydrogenase and aldehyde dehydrogenase in the Japanese: isozyme variation and its possible role in alcohol intoxication. American journal of human genetics. 1980;32(1):8.
15. Ohta S, Ohsawa I, Kamino K, Ando F, Shimokata H. Mitochondrial ALDH2 deficiency as an oxidative stress. Annals of the New York Academy of Sciences. 2004;1011(1):36-44.
16. Yin G, Ohnaka K, Morita M, Tabata S, Tajima O, Kono S. Genetic polymorphisms of alcohol dehydrogenase and aldehyde dehydrogenase: alcohol use and type 2 diabetes in japanese men. Epidemiology Research International. 2010;2011.
17. Meier-Tackmann D, Leonhardt RA, Agarwal DP, Goedde HW. Effect of acute ethanol drinking on alcohol metabolism in subjects with different ADH and ALDH genotypes. Alcohol. 1990;7(5):413-418.
18. Luczak SE, Glatt SJ, Wall TJ. Meta-analyses of ALDH2 and ADH1B with alcohol dependence in Asians. American Psychological Association; 2006.
19. Harris RA, Allan AM. Alcohol intoxication: ion channels and genetics. The FASEB journal. 1989;3(6):1689-1695.
20. Эрдэнэбаяр Л. Архидалт ба мансуурал. УБ Сэлэнгэ пресс; 2015.
21. Aleynik MK, Leo MA, Aleynik SI, Lieber CS. Polyenylphosphatidylcholine Opposes the Increase of Cytochrome P-4502E1 by Ethanol and Corrects Its Iron-Induced Decrease. Alcoholism: Clinical and Experimental Research. 1999;23(1):96-100.

22. Sutker PB, Goist KC, Allain AN, Bugg F. Acute alcohol intoxication: sex comparisons on pharmacokinetic and mood measures. *Alcoholism: Clinical and Experimental Research*. 1987;11(6):507-512.
23. Лхагсүрэн Ш. Хар тамхи мансууруулах бодисын хорын үндэс УБ 2000.
24. Бямбасүрэн С. Согтуурал ба архидалт. УБ Улсын хэвлэлийн газар; 1988.
25. Эрдэнэбаяр Л. Мансуурах дон судлал УБ 2002
26. Пүрэвдорж И. Үр удамд архины нөлөө УБ 1982.
27. Эрдэнэбаяр Л. Архичдын оюун ухааны чадамжийн бууралт. Монголын анагаах ухаан сэтгүүл. 1985(4):3.
28. Дэмидмаа Н. Архинд донтох өвчинтэй эцэг эх бүхий хүүхдүүдийн сэтгэцийн эрүүл мэндийн байдал [АУ-ны докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл]. УБ 2000.
29. Кондрашенко ВТ, Скугаревский АФ, Волков ПП. Алкоголизм. Беларусь; 1983.
30. Морозов Г, Качаев А, Лукачер Г. Алкоголизм. 1973.
31. Брайерс С, Бэвейсток С. Өсвөр бурхад. УБ Төгөлдөр сан; 2010.
32. Гурьева ВА, Гиндикин ВЯ. Юношеские психопатии и алкоголизм. Медицина; 1980.
33. Сумъяабаатар Г. Өсвөр насны хүүхдийн зан төлөвийн онцлогийг судалсан үр дүнгээс” Олон улсын ЭШ-ний хурлын эмхтгэл; 2014; .
34. Түвшинжаргал Б. Архидан согтуурлын хор уршгийг бууруулах арга зам. Гэмт явдалтай тэмцэх асуудал. 2005;1(11).
35. “Архидан согтуурахтай тэмцэх сан”-д хийсэн мониторингийн тайлан. УБ 2012.
36. МНЭММН. Эрүүл мэнд, эдийн засагт учруулах архины дарамтыг судлах. УБ 2015.
37. ГССҮТ. ГССҮТ-ийн статистик мэдээлэл. 2014.
38. WHO. Global status report on alcohol 2004. 2004.
39. ЦЕГ. Улсын хэмжээнд 2015 онд бүртгэгдсэн гэмт хэрэг 2015; <http://www.police.gov.mn/>.
40. Kingsley CM, Gupta SC. How to reduce the risk of coronary artery disease: teaching patients a healthy life-style. *Postgraduate medicine*. 1992;91(4):147-160.
41. Rehm J, Shield K, Rehm M, Gmel G, Frick U. Alcohol consumption, alcohol dependence and attributable burden of disease in Europe. *Centre for Addiction and Mental Health*. 2012.
42. Bonomo Y, Coffey C, Wolfe R, Lynskey M, Bowes G, Patton G. Adverse outcomes of alcohol use in adolescents. *Addiction*. 2001;96(10):1485-1496.
43. Эрдэнэбаяр Л, Нарантуяа Н. Монгол улс дахь архидалтын нийгмийн асуудал Сэтгэцийн эрүүл мэндийн албаны тулгамдсан асуудлууд онол практикийн бага хурлын эмхтгэл; 2009; УБ
44. US Centers for Disease Control and Prevention. www.cdc.gov.
45. Hibell B, Andersson B, Ahlström S, et al. The 1999 ESPAD report. Alcohol and other drug use among students in. 2000;30.
46. Монгол Улсын хууль. Архидан согтуурахтай тэмцэх тухай. УБ 2000.
47. Иванец Н, Винникова М. Перспективы использования Вивитрола (налтрексона длительного действия в инъекциях) в терапии алкогольной зависимости. *Неврология. Психиатрия*. 2008;16(26):1790-1796.

48. Монгол улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх архидан согтуурахтай тэмцэх бодлого,зохицуулалтын зөвлөл “Шинэ зуунд архидалтын эсрэг” үндэсний чуулган. УБ 2003:53.
49. Монгол улсын стандарт Согтууруулах ундааны техникийн ерөнхий шаардлага MNS 179 : 2009. УБ Үндэсний стандарт хэмжилзүйн газар; 2009.
50. Засгийн газрын тогтоол. Эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгааг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай. УБ 2001.
51. Монгол улсын засгийн газрын тогтоол. Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хоёр дахь хөтөлбөр батлах тухай. УБ 2014.
52. Улсын их хурлын тогтоол. Архидан согтуурахаас сэргийлэх, хяналт тавих үндэсний хөтөлбөр. УБ 2003.
53. Wechsler H, Nelson TF. Will increasing alcohol availability by lowering the minimum legal drinking age decrease drinking and related consequences among youths? American journal of public health. 2010;100(6):986-992.
54. Түвшинжаргал Б. Архины хатуулгыг бууруулж архидан согтуурахтай тэмцэх эрхзүйн орчны зарим асуудал. Гэмт явдалтай тэмцэх асуудал. 2005;1(11):38.
55. Elder RW, Shults RA, Sleet DA, et al. Effectiveness of mass media campaigns for reducing drinking and driving and alcohol-involved crashes: a systematic review. American journal of preventive medicine. 2004;27(1):57-65.
56. Norström T, Razvodovsky Y. Per capita alcohol consumption and alcohol-related harm in Belarus, 1970–2005. The European Journal of Public Health. 2010;20(5):564-568.
57. Wagenaar AC, Salois MJ, Komro KA. Effects of beverage alcohol price and tax levels on drinking: a meta-analysis of 1003 estimates from 112 studies. Addiction. 2009;104(2):179-190.
58. Pitso J, Obot IS. Botswana alcohol policy and the presidential levy controversy. Addiction. 2011;106(5):898-905.
59. Babor T. Alcohol: no ordinary commodity: research and public policy. Oxford University Press; 2010.
60. Levintova M. Russian alcohol policy in the making. Alcohol and Alcoholism. 2007;42(5):500-505.
61. Parry CD, Dewing S. A public health approach to addressing alcohol-related crime in South Africa. African Journal of Drug and Alcohol Studies. 2006;5(1):41-56.
62. Heather N, Raistrick D, Godfrey C. A Summary of the Review of the Effectiveness of Treatment for Alcohol Problems. London: National Treatment Agency for Substance Misuse. 2006.
63. Malaga H, Gonzalez M, Huaco C, Sotelo M. The relation between the number of hours that authorize the sale of alcoholic beverages and violence. Health promotion perspectives. 2012;2(1):60.